



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.02.23 № 255

танай -ны № -г

ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ГАЗРЫН ДАРГА
Э.ЖАВХЛАН ТАНАА

Татгалзсан дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийхээр байсан.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөхгүй. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

1. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2023.02.23-ны өдрийн 58 дугаар албан бичгээр Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн "8.9.1.төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх;"
2. Төсвийн гүйцэтгэлийн болон нэмэлт санхүүжилтийн тайланг гарган ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн "7.4.Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана.", Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан дүнгүүд авлага, өр төлбөр, үндсэн хөрөнгө, бараа материалын тодруулга тайлангийн эхний болон эцсийн үлдэгдлүүд хоорондоо зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Сангийн сайдын 2006 оны А/388 тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар", УСНББОУС-тай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

011021111

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой байсан.

Гэвч, дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 59 ДДБ-2024/09/НА-СТА-ТЦЗ

Чойбалсан хот

АМ40301

Г Сахилгын хариуцлага тооцуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дорнод аймгийн Хүүхэд, Гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайлангийн аудитаар татгалзсан дүгнэлт авсан, мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 4 төлөөлөгчийн "Жендер, Улс төрд эмэгтэйчүүдийн оролцоо сэдэвт сургалтаар Герман улс руу зорчсон" гэх онгоцны зардлыг санхүүжүүлсэн зөрчилд холбогдох 24.0 сая төгрөгийн төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн "42.1.Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.", "42.2.Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан ... албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно."

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Дорнод аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга Э.Жавхлан-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2024 оны 08 дугаар сарын 01-ний дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Чинбат-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011041129



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 01/73 ДДА-2024/09/ИА-СА-ТЦБ

Чойбалсан хот

АМ70309

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/70 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал"-ын 3.12-т заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын нэмэлт санхүүжилтийн данснаас Түмэн аялал ХХК-руу үйл ажиллагааны удирдамжгүй, худалдан авах ажиллагааны журмыг зөрчиж 24.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн "8.4.Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно." 3Г-ын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн "24.4.Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", 41 дүгээр зүйлийн "41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;", "41.2.7.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн "15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;", "15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн." гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

011050174

1. Зорилго, үр дүнгүй зарцуулсан 24,000,000.00 /Хорин дөрвөн сая/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Э.Жавхлан, нягтлан бодогч Ю.Жавхлан нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

И.СЭМЖИДМАА

М.УХААНБИЛЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 11 сарын 03 өдөр

Дугаар

02/74 АВА-2024/09/НА-СТА-703

Чойбалсан хот

АМТ0309

Г

Г

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/70 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал"-ын 3.12-т заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Уралдаан тэмцээн зохион байгуулж хүнсний дэлгүүрээс худалдан авалт хийх 1.3 сая төгрөгийн эрхийн бичиг олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн "15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" "15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тэмцээн уралдааны шагналд зарцуулсан 1,310,000.0 /Нэг сая гурван зуун арван мянган/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Э.Жавхлан, нягтлан бодогч Ю.Жавхлан нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

И.СЭМЖИДМАА

М.УХААНБИЛЭГ



011050223



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 03/75 ДОР-2024/09/НА-СА-ТМЗ Чойбалсан хот
1170303

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/70 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”-ын 3.12-т заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Анзаар” арга хэмжээний удирдамж болон тайланд аймгийн ЗДТГ-ын хурлын зааланд арга хэмжээг зохион байгуулж ажилласан талаар тусгасан байхад Ганхэрлэн ХХК-руу заал түрээсийн төлбөр шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн “41.2.2.батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;”, “41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгадагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Заалны түрээсийн 240,000 /Хоёр зуун дөчин мянган/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Э.Жавхлан, нягтлан бодогч Ю.Жавхлан нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА



011050182

29

АУДИТОР  М.УХААНБИЛЭГ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 254 ДАА-2023/09/11-СИА-Т113

Чойбалсан хот

АМ70309

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8.1, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын заавар аргачлал"-ын 3.12-т заасны дагуу Дорнод аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь "Саяар Дорно" ХХК-тай байгуулсан №2023/08 дугаартай гэрээнд "Сэтгэл зүйч зөвлөж байна" цуврал нэвтрүүлгийг 7 хоног тутамд бэлтгүүлж авахаар тусгасан ч хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн "41.2.6.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх," гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-д "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй," гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Саяар дорно" ХХК-тай байгуулсан 4,500,000 /Дөрвөн сая таван зуун мянган/ төгрөгийн гэрээний хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Э.Жавхлан, нягтлан бодогч Ю.Жавхлан нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

И.СЭМЖИДМАА

М.УХААНБИЛЭГ



011040805